

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД**

ОНХС-ийн 2023 онд хийгдэх ажлын иргэдээс авсан саналыг нэгтгэн багийн засаг дарга нар болон багийн ажлын албанд зөвлөгөө тусламж үзүүлэн саналыг нэгтгэн ЗДТГ-ын ажлын албанд хүргүүлсэн. Мөн аймгаас ОНХС-ын ажлын хэсэг ирж 2022, 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажил болоод 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын явцтай танилцан ажилласан.

**б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

8 дугаар сарын 4-6 ны өдрүүдэд алтан овооны 110 жилийн баяр наадамд ажлын хэсэг байгуулан зохион байгуулалттай оролцлоо.

Е- Mongolia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 5, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа - 1, жолооны үнэмлэхийн лавлагаа-1, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 12, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 3, НАХЯ-ны хилийн ба дотоодын цэрэгт цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа - 1 , нийт - 20 лавлагаа олголоо.

Пэйж хуудсанд энэ сар нийт 12 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох [Khalzan.su.gov.mn](http://Khalzan.su.gov.mn) хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

8-р дугаар сард нийт ирсэн бичиг 12, хариутай -6, үүнээс хугацаанд нь илгээсэн -6, хугацаа болоогүй -1, явсан бичиг -10 байна.

**ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:**

8 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 85.0 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 155.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулж байгаа “Амьдрах орчин-аюулгүй байдлын судалгаа”-нд хөдөөгийн Сайншандны 3 дугаар багийн 7 өрх сонгогдож тодруулгыг хийж аймгийн статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалттай холбоотой бичиг баримт, программд оруулах мэдээллийг холбогдох мэргэжилтэнгүүд оруулж дуусгалаа.

**ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:**

Засгийн газрын 2023 оны 240 болон 241 дүгээр тогтоолуудаар ЗДТГ ын албан хаагчдад сонсгол мэдээллийн цагаар мэдээлэл өгч ажиллав.

Мөн үер ус их байгаатай холбоотой үер ус, тогтоол усанд бага насны хүүхдийг унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор брошур тараан цахим худсаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.

## **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

**Эрүүл мэндийн чиглэлээр:** 2023 оны 08 сард Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал Үйлчүүлэгчийг танин тодруулах, Амилуулах тусламж үйлчилгээний сургалтанд эмч мэргэжилтэнгүүд ЭМГ-т сургалтанд хамрагдсан .

**Мал эмнэлэгийн чиглэлээр:** Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын татан авалтыг хийж 4 багийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 26,700 хурганд хийх 170, 153,169 серийн дугаартай 100 тунтай 26700 тун вакциныг 4 аж ахуй нэгжид хувиарлаад байна. Нийт 36 өрхийн 1650 хурга хамрагдаад байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 35907 охин төл хамрагдана. REV-1 33476, Штам-19 2431 тун вакцин татан авч хувиар хийгээд байна.

Жил бүр хийгддэг мал угаалгын ажил 2023 оны 08 сарын 10 ны өдрөөс эхлэн 3 цэгт угаалга эхлэж 20600 мал угаагаад байна.

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 02 тоот албан даалгаварын биелэлтийг гаргаж аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэв

Байгаль хамгаалах зардлаас 64.5 сая төгрөгөөр хог зөөврийн өөрөө буулгагч КАМА маркийн авто машиныг худалдан авлаа.

Байгалийн нөөц ашигласаны тухай хуулийн хэрэгжилт түүнийг захиран зарцуулах тухай зөвлөгөөн Баруун-Урт суманд болж үүнд сумын ИТХ-ын дарга Ө. Золжаргал, Санхүү төрийн сангийн мэргэжилтэн Д. Гэрэлцэцэг нарын хамт оролцлоо

Сумын төвийн айл өрхүүдийн хашааны элсийг зөөж цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ

**ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:**  
М.ХУЯГ

**МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН**  
Д.ДАЙРИЙМАА

